



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/43

Номгон

Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох  
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.1, 7.12.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төвийн болон зүүн бүсийн нутаг дэвсгэрээс отор нүүдэл, үйлдвэрлэл худалдаа, үржлийн болон бусад зорилгоор хивэгч амьд мал, амьтан зөөвөрлөж тээвэрлэн тус аймгийн нутаг дэвсгэрт байршуулахыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хориглосугай.

2.Малчид, мал бүхий иргэдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөн, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлж, ард иргэдэд уг захирамжийг танилцуулж мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Цагдаагийн газар /Б.Оюутболд/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210103